



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
 ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 08 сарын 22 өдөр

Дугаар А/544

Алтай хот

┌ Хорио цээрийн дэглэм тогтоох тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.22, 4.1.23 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 08 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус аймгийн Есөнбулаг сумын нутаг дэвсгэрт тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол илэрсэнтэй холбогдуулан тухайн нутаг дэвсгэрт хорио цээрийн дэглэм тогтоож, голомтот бүсээс гарах тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 18:00 цагаас 2022 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 19:00 цаг хүртэл хязгаарласугай.

2.Хязгаарлалтын хугацаанд бүх үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар), Цагдаагийн газар (Н.Мэндбаяр), Онцгой байдлын газар (Л.Баянбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

3.Сэжигтэй тохиолдлын тархвар зүйн зураглал гарган 1-р хавьталыг илрүүлж, голомтын хүрээг тогтоохыг Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал), Цагдаагийн газар (Н.Мэндбаяр)-т тус тус даалгасугай.

4.Тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол илэрсэнтэй холбоотойгоор гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр шуурхай арга хэмжээ авч, аймгийн онцгой комиссыг мэдээллээр хангаж ажиллахыг нийт сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

5.Тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлоос дээжилсэн лабораторийн шинжилгээний сорьцыг Зооноз өвчин судлалын үндэсний төвд шуурхай хүргүүлэхийг Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал)-т даалгасугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, Онцгой комиссын хурлыг тухай бүр шуурхай хуралдуулж, Улсын онцгой комисст мэдээллэж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР